

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/109/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Дорноговь аймаг Сайншанд сум
2020 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа
Утас: 70522734 Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn
Аудитын менежерийг түр орлон гүйцэтгэгч: Э.Энхцэцэг
Утас: 70523020 Цахим хаяг: injig78@yahoo.com
Аудитор: Ц.Энхтуяа
Утас: 99042645 Цахим хаяг: shilenbalanceaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан.....	5
2.1.	Оршил.....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11.	Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.12.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.13.	Шилэн дансны мэдээлэл	9
2.14.	Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.15.	Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал	11
3.1	БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/.....	12
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/.....	13
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/	14
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/.....	16
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/.....	16
4.6	Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/	17

1 Аудитын гэрчилгээ



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн эмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.02.28 № 9-6/182

танай _____ -ны № _____ -т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ЭРДЭНЭ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА С.ЦЭЦЭГСҮРЭН
ТАНАА

Аудитын гэрчилгээ

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг С.Цэцэгсүрэнд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Шилэн баланс аудит ХХК-ийн аудитор Ц.Энхтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төв 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 06 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төв нь иргэн бүрт эрүүл мэндийн боловсрол, тусламж үйлчилгээний тэгш хүртээмж, аюулгүй байдал, ёс зүйг хангаж үйлчилнэ гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эмнэлгийн газар эмчилгээ үйлчилгээ явуулах.

Байгууллагын төсвийн захирагч нь Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль бусад холбогдох эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж түүнд нийцүүлэн гаргасан журам зааварт өөрчлөлт ороогүй байна.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн Acolous програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн, гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд 43 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 2 хувиар сонгов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 345,152.9 мянган төгрөгөөс тооцон 6,903.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 22,544.2 мянган төгрөгөөр буюу 15.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	5,790.6	-	(5,790.6)
Бараа материал	29,582.1	67,115.2	37,533.1
Үндсэн хөрөнгө	113,370.9	104,172.6	(9,198.3)
Нийт хөрөнгө	148,743.6	171,287.8	22,544.2
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	148,743.6	171,287.8	22,544.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	148,743.6	171,287.8	22,544.2

Тээвэр шатахуунтай холбоотой 1,542.0 мянган төгрөг, эмийн авлага 2,86.2 мянган төгрөг, бусад зардлыг тооцооны авлага 1,762.3 мянган төгрөгийн авлага тус тус барагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь тусгай зориулалтын материал 8,298.3 мянган төгрөгөөр, эм боох материал 33,908.3 мянган төгрөгөөр, бичиг хэргийн материал 3,680.7 мянган төгрөгөөр, аж ахуйн материал 3,072.5 мянган төгрөгөөр, сэлбэг хэрэгсэл 429.9 мянган төгрөгөөр, түлш шатахуун 15,067.7 мянган төгрөгөөр, барилгын материал 569.5 мянган төгрөгөөр, хүнсний материал 4,648.7 мянган төгрөгөөр, бусад хангамжийн материал 7,920.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж нийт 40,065.8 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас 37,533.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Бүх нэр төрлийн бараа материал бүрэн ашиглагдах буюу ашиглагдаж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл нь 5,188.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 3,918.8 мянган төгрөгийн тавилга эд хогшил шинээр бэлтгэж, 19,784.0 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдлийн зардал тооцооноос 9,198.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл үндсэн хөрөнгө шинээр бэлтгэсэн, хуримтлагдсан үр дүнгээс хамаарч 22,544.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд нийт 365,770.9 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсанаас гүйцэтгэлээр 363,042.4 мянган төгрөгийн санхүүжилт авч 99.0 хувьтай байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөгөөр/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Улсын төсвөөс санхүүжих	309,294.5	309,294.5	-	100.0
Орон нутгийн төсвөөс санхүүжих	32,430.6	32,430.6	-	100.0
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	24,045.8	20,332.6	(3,713.2)	84.6
Үндсэн үйл ажиллагааны орлого	-	984.7	(984.7)	
Нийт дүн	365,770.9	363,042.4	(2,728.5)	99.0

Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих санхүүжилт 3,713.2 мянган төгрөгөөр дутуу санхүүжсэн нь эмнэлгээр үйлчлүүлэгчдийн тоо төлөвлөгөөнд хүрээгүй төсвийн төлөвлөлттэй холбоотой байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 төсөл хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2019 онд 365,641.9 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Урсгал зардлыг хэмнэсэн нь цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлыг 3,667.5 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 3,758.1 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 7.3 мянган төгрөгөөр, хангамжийн материалын зардлыг 6,229.2 мянган төгрөгөөр, норматив зардлыг 4,359.2 мянган төгрөгөөр, томилолт зочны зардлыг 1,116.2 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 57.8 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 832.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалжээ.

Нэмэлт төсөв: Дээд шатны төсвийн захирагчаас 2,624.8 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлогоос 984.7 мянган төгрөгийн нийт 3,609.5 мянган төгрөг орсон байна.

Үүнээс тээвэр, шатахууны зардалд 37.8 мянган төгрөг, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардалд 100.0 мянган төгрөг, эм бэлдмэлийн зардалд 941.0 мянган төгрөг, дотоод томилолтын зардалд 76.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 25.4 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 4 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 3 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 431.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснийг төлбөрийн акт тогтоолоо. Үүнд

Тус Эрүүл мэндийн төв нь 2019 оны амралтын олговрыг тооцон олгохдоо хоног давхардуулан тооцоолж 8 хүнд нийт 431.5 мянган төгрөгийг зөрүүтэй олгосон байна. Энэ нь Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаал, Төсвийн тухай хуулийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоосон.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төв Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 142 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2019 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ

3.1.1 Илрүүлэлт:

Бараа материалуудыг дансны ангилал зөрүүлж бүртгэсэн байна. Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна УСНББОУС, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалыг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Дансны ангилал буруу бүртгэгдэх,

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 4.16 “*Бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг стандартыг мөрдөнө.*” заалтыг хэрэгжүүлж ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	35,372,723.14	67,115,158.65
33	АВЛАГА	5,790,633.60	-
335	Бусад авлага	5,790,633.60	-
3351	Байгууллагаас авах авлага	5,790,633.60	-
35	БАРАА МАТЕРИАЛ	29,582,089.54	67,115,158.65
351	Түүхий эд материал	13,165,237.26	35,460,946.05
35110	Тусгай зориулалттай материал	12,829,459.70	21,127,839.70
35130	Эм боох материал	335,777.56	14,333,106.35
354	Хангамжийн материал	16,416,852.28	31,654,212.60
35410	Бичиг хэргийн материал	1,619,216.00	2,986,101.00
35420	Аж ахуйн материал	360,923.00	2,289,789.00
35440	Түлш, шатах тослох материал	-	3,040,410.00
35450	Барилгын засварын материал	40,000.00	40,000.00
35460	Хүнсний материал	649,688.28	1,815,697.60
35470	Бусад хангамжийн материал	13,747,025.00	21,482,215.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	113,370,908.87	104,172,638.07
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	113,370,908.87	104,172,638.07
391	Газар	-	-
392	Биет хөрөнгө	92,446,908.87	83,062,638.07
39201	Барилга, байгууламж, орон сууц	49,736,620.00	49,736,620.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(6,590,097.12)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	55,036,434.00	55,036,434.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(31,521,608.25)	(37,644,347.25)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	69,282,459.66	74,470,459.66
39206	Хуримтлагдсан элэгдэл	(54,957,942.86)	(60,037,704.15)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,899,648.40	19,818,448.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,184,868.50)	(13,500,875.27)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,485,000.00	3,693,900.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,535,281.58)	(2,126,648.20)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	-	-
39217	Ном	206,448.00	206,448.00
393	Биет бус хөрөнгө	20,924,000.00	21,110,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	21,309,000.00	21,579,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(385,000.00)	(469,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	148,743,632.01	171,287,796.72
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	148,743,632.01	171,287,796.72
51	Засгийн газрын хувь оролцоо	148,743,632.01	171,287,796.72
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	205,923,538.50	205,923,538.50
51101	Өмч: - төрийн	205,923,538.50	205,923,538.50
512	Хуримтлагдсан үр дүн	(60,501,316.49)	(37,957,151.78)
51210	Өмнөх үеийн үр дүн	(60,501,316.49)	(60,501,316.49)
51220	Тайлант үеийн үр дүн	-	22,544,164.71
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	-	-
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,321,410.00	3,321,410.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	148,743,632.01	171,287,796.72

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	263,710,301.42	377,034,442.96
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,703,567.42	320,661,752.96
120	Нийтлэг татварын бус орлого	4,703,567.42	11,367,252.96
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,703,567.42	11,367,252.96
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	38,700.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,664,867.42	11,367,252.96
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	309,294,500.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	-	309,294,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	259,006,734.00	56,372,690.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	256,503,500.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	256,503,500.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,416,800.00	1,220,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,416,800.00	1,220,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	32,430,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	32,430,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	86,434.00	22,722,090.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	86,434.00	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	22,722,090.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	274,065,223.39	354,490,278.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	274,065,223.39	354,490,278.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	274,065,219.39	335,156,966.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	159,899,409.80	212,309,295.00
210101	Үндсэн цалин	157,292,390.80	198,489,497.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	2,178,000.00
210104	Урамшуулал	2,607,019.00	11,641,798.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,154,691.00	26,904,433.93
210201	Тэтгэврийн даатгал	12,686,960.00	18,993,980.93
210202	Тэтгэмжийн даатгал	1,547,172.00	1,888,723.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,269,737.00	1,891,296.00
210204	Ажилгүйдлийн даатгал	317,435.00	375,491.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,333,387.00	3,754,943.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,165,001.00	31,423,332.00
210301	Гэрэл, цахилгаан	1,435,724.00	2,080,410.00
210302	Түлш, халаалт	28,680,660.00	27,125,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,048,617.00	2,217,922.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,106,881.00	15,823,449.00
210401	Бичиг хэрэг	2,270,578.00	1,836,775.00
210402	Тээвэр, шатахуун	9,380,080.00	11,892,510.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	660,600.00	966,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,122,698.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	68,100.00	1,127,664.00
210408	Бараа материал акталсны зардал	3,604,825.00	-
2105	Нормативт зардал	19,910,520.70	21,782,229.98
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,244,722.18	18,704,184.30
210502	Хоол, хүнс	3,665,798.52	3,078,045.68
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	720,600.00	999,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	63,000.00	-
210604	Урсгал засвар	657,600.00	999,400.00
2107	Томилолт, зочны зардал	651,800.00	931,100.00
210702	Дотоод албан томилолт	651,800.00	931,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	490,650.00	533,818.00

«Audit_name» Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн «Audit_year» оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	хураамж		
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	128,500.00	25,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.00	160,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	97,650.00	249,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	5,000.00	51,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	25,000.00
210807	Газрын төлбөр	106,500.00	23,218.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,965,665.89	24,449,908.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,448,985.00	4,665,938.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,516,680.89	19,783,970.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4.00	19,333,311.54
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	19,333,311.54
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	19,333,311.54
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(10,354,921.97)	22,544,164.71
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	159,221,192.30	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	493,221.22	-
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	158,727,971.08	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(159,221,192.30)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(169,576,114.27)	22,544,164.71

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	258,959,000.00	365,667,190.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	38,700.00	309,294,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	38,700.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	38,700.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	38,700.00	-
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	309,294,500.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	-	309,294,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	258,920,300.00	56,372,690.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	256,503,500.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	256,503,500.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,416,800.00	1,220,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,416,800.00	1,220,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	32,430,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	32,430,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	22,722,090.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	22,722,090.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	254,077,000.00	357,240,390.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	254,077,000.00	357,240,390.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	253,965,383.00	337,907,078.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	161,402,230.00	212,452,506.00
210101	Үндсэн цалин	150,902,256.00	166,400,000.00
210102	Нэмэгдэл	-	29,819,273.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	3,581,000.00
210104	Урамшуулал	10,499,974.00	12,652,233.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,771,656.00	24,969,378.93
210201	Тэтгэврийн даатгал	13,223,656.00	17,058,925.93

«Audit_name» Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн «Audit_year» оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210202	Тэтгэмжийн даатгал	1,637,000.00	1,888,723.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,309,600.00	1,891,296.00
210204	Ажилгүйдлийн даатгал	327,400.00	375,491.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,274,000.00	3,754,943.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,179,817.00	31,423,332.00
210301	Гэрэл, цахилгаан	1,033,600.00	2,080,410.00
210302	Түлш, халаалт	26,097,600.00	27,125,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,048,617.00	2,217,922.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,843,415.00	19,614,460.00
210401	Бичиг хэрэг	1,247,850.00	2,229,460.00
210402	Тээвэр, шатахуун	12,568,100.00	13,209,580.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	605,600.00	1,029,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,421,865.00	146,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	2,999,320.00
2105	Нормативт зардал	20,556,915.00	36,525,285.53
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,099,115.00	29,288,330.53
210502	Хоол, хүнс	3,627,600.00	4,237,955.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	830,200.00	2,999,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,055,850.00	4,296,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	350,250.00	2,940,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	357,000.00
210604	Урсгал засвар	705,600.00	999,400.00
2107	Томилот, зочны зардал	833,200.00	960,600.00
210702	Дотоод албан томилот	833,200.00	960,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,276,650.00	533,818.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,886,300.00	25,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.00	160,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	97,650.00	244,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	51,200.00	51,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	17,500.00	30,000.00
210807	Газрын төлбөр	104,000.00	23,218.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,045,650.00	7,130,798.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,045,650.00	7,130,798.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	111,617.00	19,333,311.54
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	111,617.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	111,617.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	19,333,311.54
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	19,333,311.54
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>4,882,000.00</u>	<u>8,426,800.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,882,000.00	8,426,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,882,000.00	8,426,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,882,000.00	8,426,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,882,000.00	8,426,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(4,882,000.00)</u>	<u>(8,426,800.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	184,999,538.50	77,683,335.73	109,186,410.78	371,869,285.01
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	184,999,538.50	77,683,335.73	109,186,410.78	371,869,285.01
Тайлант үеийн үр дүн	20,924,000.00	-	(169,576,114.27)	(148,652,114.27)
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	205,923,538.50	3,321,410.00	(60,501,316.49)	148,743,632.01
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	205,923,538.50	3,321,410.00	(60,501,316.49)	148,743,632.01
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	205,923,538.50	3,321,410.00	(60,501,316.49)	148,743,632.01
Тайлант үеийн үр дүн	-	-	22,541,164.71	22,541,164.71
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	205,923,538.50	3,321,410.00	(37,960,151.78)	171,284,796.72

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өөрчлөлт	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	365,641,900.00	345,152,878.46	(20,489,021.54)	94.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	365,641,900.00	345,152,878.46	(20,489,021.54)	94.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	365,641,900.00	345,152,878.46	(20,489,021.54)	94.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	216,120,000.00	212,452,506.00	(3,667,494.00)	98.3
210101	Үндсэн цалин	166,400,000.00	166,400,000.00	-	100.0
210102	Нэмэгдэл	33,100,000.00	29,819,273.00	(3,280,727.00)	90.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,620,000.00	3,581,000.00	(39,000.00)	98.9
210104	Урамшуулал	13,000,000.00	12,652,233.00	(347,767.00)	97.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,727,500.00	24,969,378.93	(3,758,121.07)	86.9
210201	Тэтгэврийн даатгал	19,974,700.00	17,058,925.93	(2,915,774.07)	85.4
210202	Тэтгэмжийн даатгал	2,188,200.00	1,888,723.00	(299,477.00)	86.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,750,600.00	1,891,296.00	140,696.00	108.0
210204	Ажилгүйдлийн даатгал	437,600.00	375,491.00	(62,109.00)	85.8
210205	Эрүүл мэндийн даатгал	4,376,400.00	3,754,943.00	(621,457.00)	85.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,430,600.00	31,423,332.00	(7,268.00)	100.0
210301	Гэрэл, цахилгаан	2,040,000.00	2,080,410.00	40,410.00	102.0
210302	Түлш, халаалт	27,119,400.00	27,125,000.00	5,600.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	2,271,200.00	2,217,922.00	(53,278.00)	97.7
2104	Хангамж, бараа материалын зардал	25,975,900.00	19,746,660.00	(6,229,240.00)	76.0
210401	Бичиг хэрэг	3,016,700.00	2,229,460.00	(787,240.00)	73.9
210402	Тээвэр, шатахуун	17,159,200.00	13,171,780.00	(3,987,420.00)	76.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,300,000.00	1,299,500.00	(500.00)	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500,000.00	46,600.00	(1,453,400.00)	3.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,000,000.00	2,999,320.00	(680.00)	100.0
2105	Нормативт зардал	39,943,500.00	35,584,285.53	(4,359,214.47)	89.1
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	30,943,500.00	28,347,330.53	(2,596,169.47)	91.6
210502	Хоол, хүнс	6,000,000.00	4,237,955.00	(1,762,045.00)	70.6
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,000,000.00	2,999,000.00	(1,000.00)	100.0

«Audit_name» Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн «Audit_year» оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,055,000.00	11,593,900.00	(461,100.00)	96.2
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,000,000.00	8,998,500.00	(1,500.00)	100.0
210602	Тавилга	1,055,000.00	989,000.00	(66,000.00)	93.7
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.00	607,000.00	(393,000.00)	60.7
210604	Урсгал засвар	1,000,000.00	999,400.00	(600.00)	99.9
2107	Томилолт, зочны зардал	2,000,000.00	883,800.00	(1,116,200.00)	44.2
210702	Дотоод албан томилолт	2,000,000.00	883,800.00	(1,116,200.00)	44.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	566,200.00	508,418.00	(57,782.00)	89.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	160,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	245,000.00	244,000.00	(1,000.00)	99.6
210804	Тээврийн хэрэгслийн татвар	51,200.00	51,200.00	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	30,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	80,000.00	23,218.00	(56,782.00)	29.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,823,200.00	7,990,598.00	(832,602.00)	90.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,823,200.00	7,990,598.00	(832,602.00)	90.6
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	365,770,900.00	362,057,690.00	(3,713,210.00)	99.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	309,294,500.00	309,294,500.00	-	100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	309,294,500.00	309,294,500.00	-	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	32,430,600.00	32,430,600.00	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	32,430,600.00	32,430,600.00	-	100.0
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	24,045,800.00	20,332,590.00	(3,713,210.00)	84.6
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	24,045,800.00	20,332,590.00	(3,713,210.00)	84.6

4.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,181,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,181,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,181,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	137,800.00
210402	Тээвэр, шатахуун	37,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100,000.00
2105	Нормативт зардал	941,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	941,000.00
2107	Томилолт, зочны зардал	76,800.00
210702	Дотоод албан томилолт	76,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,400.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,609,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,609,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,624,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	984,700.00